

## ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**В.ПҮРЭВБААСАН**

ДХИС-ийн Удирдлагын Академийн Хилийн албаны удирдлага стратегийн профессорын  
багийн дэд профессор, доктор(Ph.D), хурандаа

**Хураангуй.** Цагийн байдлын өөрчлөлт, дайн, байлдааны үед цэргийг хамгаалах асуудал нь цэргийн шинжлэх ухаанд цэргийн хамгаалалт нэртэйгээр хэрэгждэг бол тайван цагт цэргийн албаны аюулгүй байдлыг хангах гэсэн ойлголт, арга хэмжээгээр хэрэгжиж байна. Хилийн цэргийн албаны аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын асуудал нь удирдлагын тогтолцооны хувьд цэргийн удирдлага, эрсдэлийн удирдлага, төрийн захиргааны удирдлага зэрэг удирдлагын онолын гурван төрлийн ерөнхий шинж, чиг үүргүүдийг өөртөө агуулдаг. Иймд удирдах албан тушаалтан нь тухайн нөхцөл байдалд тохируулж, удирдлагын чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ.

**Түлхүүр үг:** Хилийн цэргийн албаны аюулгүй байдал (ХЦААБ), цэргийн албаны аюулгүй байдлын комисс, удирдлага, зохион байгуулалт.

### Оршил

ХЦААБ-ыг хангах удирдлага нь цэргийн алба хаагчдын амь нас, эрүүл мэнд, орон нутгийн иргэд, тэдгээрийн өмч, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй хор хохирлоос урьдчилан сэргийлэх, цэргийн албанд хортой, аюултай хүчин зүйлийг илрүүлэн оношлох, цэргийн алба хаах аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, цэргийн нийтлэг дүрэм, түүнтэй уялдуулан гаргасан ХХЕГ-ын даргын эрх зүйн зохицуулалтын актуудад заасан шаардлагуудыг биелүүлэхэд чиглэсэн цэргийн анги байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудын зорилго бүхий цогц үйл ажиллагаагаар хэрэгждэг.

### Үндсэн хэсэг

ХЦААБ-ыг хангах удирдлагыг хилийн цэргийн анги байгууллагын дарга (захирагч) хэрэгжүүлнэ. ХЦААБ-ын хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэгч, хэлтэс, албадын уялдааг хангуулах, хяналт, шалгалтын дүн, тайлан судалгаанд дүн шинжилгээг хийн, холбогдох шийдвэрийн санал гаргах үндсэн нэгж нь “Цэргийн албаны аюулгүй байдлын комисс” байна.

**Цэргийн албаны аюулгүй байдлын комисс:** ХЦААБ-ын комисс (цаашид комисс гэх) цэргийн албаны аюулгүй байдлыг хангах ажлыг сайжруулах, цэргийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах аюулгүй нөхцөлийг бий болгох талаар албан тушаалтнуудад практик дэмжлэг үзүүлэх чиглэлээр анги байгууллагын захирагч нарт хамтын санал боловсруулах, тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй зөвлөлдөх байгууллага юм. ХХБ-ын хэмжээнд ХЦ-ийн штабын даргаар ахлуулсан Комиссыг ХХЕГ-ын даргын тушаалаар, хилийн цэргийн ангид Захирагчийн 1 дүгээр орлогч, штабын даргаар ахлуулсан комиссыг ангийн захирагчийн тушаалаар тус тус баталж томилно. Комиссын бүрэлдэхүүнд ангийн захирагчийн орлогч нар, албадын дарга нар, цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий албан тушаалтан багтана. Комиссын орлогч дарга нь ХХЕГ-т ХШҮДАГ-ын дарга, хилийн цэргийн ангид Дотоод хяналтын алба ба нарийн бичгийн дарга нь ЦААБ, эрсдэлийн үнэлгээ хариуцсан ахлах офицер байна.

**Комиссын үндсэн зорилго нь:** Цэргийн албаны аюулгүй байдлын талаар мэдээлэл цуглуулах, бүртгэх, боловсруулах, арга хэмжээ зохион байгуулах, цэргийн албанд аюултай хүчин зүйлийг цаг тухайд нь илрүүлэх, ЦАХ-дыг аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэхэд бэлтгэх ажлыг сайжруулах, цэргийн албаны аюулгүй ажиллагааны нөхцөлийг тодорхойлоход оршино.

### Комиссын бүрэлдэхүүний бүрэн эрх.

#### Комиссын дарга:

- ХХЕГ-ын даргын УХХ-ыг удирдан зохион байгуулах удирдамжийн хугацаанд хийж гүйцэтгэх комиссын ажлын төлөвлөгөө, комиссын хурлын хэлэлцэх асуудлыг ХХЕГ-ын даргаар болон ангийн захирагчаар батлуулна;

- комиссын хурал болох хугацаа, газрыг тодорхойлно;

- комиссын хурлыг зохион байгуулж явуулна;

- ангийн захирагчид албаны аюулгүй байдлыг хангах асуудлаар албан

тушаалтнуудын саналыг комиссын хурал дээр сонсож хэлэлцэх талаар санал бэлтгэнэ;

- харьяа салбар, албадын албаны аюулгүй байдлын талаар ангийн захирагчид илтгэл хүргүүлнэ.

*Комиссын гишүүд нь:*

1. комиссын хуралдаан дээр авч хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэхэд оролцоно;

2. комиссын ажлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудал, хэлэлцэж буй асуудалд санал бэлтгэн оруулна;

3. комиссын даргын тушаалаар комиссын хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэж, комиссын ажлын төлөвлөгөөний биелэлтийг илтгэнэ;

4. ангийн захирагчийн тушаалын дагуу албаны аюулгүй байдлын шаардлагын биелэлтийг шалгана.

*Комиссын нарийн бичиг:*

1. комиссын ажлыг зохион байгуулалт, техникийн талаас хангана;

2. комиссын даргын удирдлагаар комиссын ажлын төлөвлөгөө, комиссын хурлаар хэлэлцэх асуудал, лавлагаа мэдээллийн материал, комиссын хуралд шаардлагатай бусад бичиг баримтыг бэлэн болгоно;

3. комиссын гишүүдэд ээлжит хурлын огноо, хугацаа, явагдах газар, хэлэлцэх асуудлын мэдээллийг хүргэнэ;

4. хурлын тэмдэглэл хөтөлнө;

5. комиссын ажлын төлөвлөгөөний биелэлт, комиссын даргын өгсөн үүргийг комиссын гишүүд хэрхэн биелүүлж буйд хяналт тавина;

6. комиссын бичиг хэргийг хөтөлнө;

7. комиссын ажлын төлөвлөгөөнд гишүүд болон албан тушаалтнуудын оруулах саналыг нэгтгэнэ;

8. харьяа салбар, албадын албаны аюулгүй байдал ямар төвшинд байгаа талаар ангийн захирагчид хүргэх илтгэлийн төслийг бэлтгэнэ.

***Комиссын үйл ажиллагааг зохион байгуулах нь:***

- ХХЕГ-ын даргын болон хилийн цэргийн ангийн захирагчийн баталсан тухайн сургалтын жилийн ажлын төлөвлөгөөний дагуу комиссын ажил зохион байгуулагдана;

- тухайн сургалтын жилийн комиссын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан улиралд нэгээс цөөнгүй удаа комиссын хурлыг зохион байгуулна.

- комиссын ажлын үр дүн, гаргасан шийдвэрийн талаар комиссын дарга сар бүр ХХЕГ-ын дарга болон ангийн захирагчид бичгээр илтгэнэ;

- Илтгэлд ХХЕГ-ын болон ангийн ЦААБ, комиссын ажлын төлөвлөгөөний биелэлт, тодорхой арга хэмжээний үед илэрсэн зөрчил, түүнийг арилгах санал, зэргийг тусган, ЦАХ-дын нас баралт, шархдалт, гэмтлийн шалтгааныг судалж, тухайн тайлант хугацааны статистик материалыг хавсарган, ХХЕГ, хилийн цэргийн ангийн албаны аюулгүй байдлыг сайжруулах санал, ангийн захирагчийн тушаалаар алба хаагчдад хүргэсэн үүргийг биелүүлэх чиглэлээр албан тушаалтнуудын хийж гүйцэтгэж буй ажлын талаар тусгана.

***Комисс нь дараах асуудлуудыг судалж, санал боловсруулна.***

1. бие бүрэлдэхүүнийг ангийн өдөр тутмын үйл ажиллагааны явцад үүсэн бий болох болон гаднын аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах нөхцөлийг хангасан байдал, тухайн нөхцөлийг бий болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн;

2. албан сургалт, бэлтгэл (марш, сургуулилт, буудлага үйлдэх), зэвсэг, цэргийн болон тусгай техник ашиглах, харуулын болон дотоодын харуул хамгаалалт, тусгай ажил, хичээл явуулах;

3. ангийн болон хилд үүрэг гүйцэтгэх тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх;

4. цэргийн албаны аюулгүй байдлын хангалтыг сайжруулах зэрэг болно.

Түүнчлэн ангийн захирагчийн заавраар:

- ЦААБ-ыг хангах чиглэлээр шийдвэр гаргахад нь санал бэлтгэн оруулах;

- ЦААБ-ыг хангах асуудлаар тушаалын төсөл бэлтгэх;

- ЦААБ-ыг хангах ажлыг төлөвлөх;

- ангийн өдөр тутмын үйл ажиллагаанд ЦААБ-ыг хангах чиглэлээр цогц дадлагын хичээл, уралдаан тэмцээн, бага хурал, сарын ажил зохион байгуулж явуулахад оролцох;

- албан тушаалтнуудад ЦААБ-ыг хангах практик ажлын чиглэлээр сургалт

явуулж, тэдэнд мэдээлэл- сурталчилгааны ажил явуулахад оролцох;

- ЦААБ-ыг хангах чиглэлээр үүрэг хүлээсэн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд дүгнэлт судалгаа хийж, ангийн өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах аюулгүй нөхцөлийг бий болгосон ажлын туршлагыг нь нэгтгэн дүгнэж, түгээн дэлгэрүүлэх;

- ЦААБ, эрсдэлийн үнэлгээ хариуцсан ажилтны санал хүсэлтийг сонсох;

- хилийн цэргийн ангийн өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавихад оролцоно.

#### **ХЦААБ-ыг хангах шийдвэр гаргах:**

ХХЕГ-ын дарга “УХХ-ыг удирдан зохион байгуулах удирдамж”-даа ХЦААБ-ыг хангах холбогдох заалтыг оруулна.

Энэ заалтын дагуу хилийн цэргийн ангийн захирагч (дарга) ЦААБ-ыг хангах шийдвэрийг гаргаж, “ЦААБ-ыг хангах, албыг зохион байгуулах” тушаалаар баталгаажуулна.

Шийдвэр гаргахын өмнө цэргийн албаны аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн даргын орлогч, албадын дарга, мэргэжилтнүүд анхдагч мэдээллийг судалж нягтлах, даргад хүргэх саналыг бэлтгэх, цагийн байдлыг үнэлэх ажил хийгдэнэ.

*Шийдвэрт захирагч:*

1. цэргийн албаны аюултай хүчин зүйлүүдийг хязгаарлах арга хэмжээ;

2. ЦАХ-ийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан цэргийн анги байгууллага, түүний салбар, албадын өдөр тутмын үйл ажиллагааны арга хэмжээг биелүүлэхэд тавигдах аюулгүй байдлын шаардлага;

3. ЦААБ-ыг хангах зохион байгуулалтын болон техникийн цогц арга хэмжээ зэргийг тодорхойлдог.

*Шийдвэрт нэмэлтээр:*

- аюултай болон хортой хүчин зүйлийг заасан объектуудын мэдээллийн хүснэгт;

- онц аюултай нэг удаагийн ажлын (ЦАХ-ийн албан үүрэгт хамааралгүй жагсаалт), түүнийг аюул осолгүй гүйцэтгэх журам;

- аюулгүй байдлыг хангах шаардлагыг хилчдэд хүргэх зааварчилга, явуулах хөтөлбөр;

- ЦААБ-ын зорилтуудыг хангах арга хэмжээний жагсаалт;

- аюулгүй байдлыг хангах комисс, баг, бүлгийн тооны болон албан тушаалын бүрэлдэхүүн;

- албан тушаалтнуудын удирдах, харилцан ажиллах схем зэргийг тусгана.

Шийдвэрийг үндэслэн цэргийн анги байгууллага дээр албан тушаалтнуудын хүлээх үүргийг боловсруулах буюу тодотгол хийнэ. Үүнд:

ЦААБ-ыг хангах асуудлаар боловсруулагдсан төлөвлөгөөт бичиг баримтад тухайн асуудлын зорилго, зорилт, арга хэмжээ, хариуцах эзнийг тусгасан байна;

Цэргийн албаны аюулгүй нөхцөлийг бий болгох, хангах ажил зохиогдоно.

#### **ХЦААБ-ыг хангах арга хэмжээг төлөвлөх:**

ХЦААБ-ыг хангах арга хэмжээг төлөвлөх нь сургалтын явцад (хичээлийн жил) хилийн цэргийн ангид өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхийд нь төлөвлөх ажлын нэг бүрдэл хэсэг юм. Энэ нь хариуцсан хэсэгт улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах тушаалыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй хамт хэрэгжих бөгөөд даргын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний системийг багтаадаг.

ХЦААБ-ыг хангах ажлыг зохион байгуулахын тулд тухайн ангид боловсруулсан дэг журам тогтоох, цэргүүдийн алба гүйцэтгэлийг сайжруулах, ЦААБ-ыг хангах цогц төлөвлөгөөнд (цаашид цогц төлөвлөгөө гэх) “ХЦААБ-ыг хангах нь” гэсэн тусдаа бүлэг оруулж өгнө. Энэ бүлэгт ХЦААБ-ын тогтолцоог бүрдүүлэгч элементүүдийн аюулгүй байдлыг хангах 26 арга хэмжээ, ХЦААБ-ын хангах үйл ажиллагааны 11 чиглэлийг (нэмэлтээр ХЦААБ-ыг хангах 55 арга хэмжээ байж болно) тусган хэрэгжүүлнэ.

Цогц төлөвлөгөөний “ХЦААБ-ыг хангах нь” гэсэн бүлэгт тусгагдсан арга хэмжээний жагсаалтыг ЦАХ амь насаа алдсан эсэх, тэдний гэмтэл бэртэл, шарх авсан шалтгаан, нөхцөл байдлын судалгааны үр дүн, шийдвэр, тухайн жилийн хугацаанд албаны бэлэн байдлыг хангах, түүнийг биелүүлэх нөхцөл зэргийг харгалзан боловсруулна.

Цогц төлөвлөгөөнд тусгагдсан ХЦААБ-ыг хангах арга хэмжээ, мөн түүнчлэн дээд дарга нарын дэвшүүлсэн тодорхой зорилт, нөхцөл байдлын өөрчлөлт, тушаал шийдвэр, удирдамж, зааврыг хэрэгжүүлэх зайлшгүй арга хэмжээ зэрэг нь ангийн сарын үндсэн ажлын

төлөвлөгөө, анги салбарын хүмүүжлийн ажлын төлөвлөгөө, салбар, албадын хичээлийн төлөвлөгөө, албан тушаалтнуудын сар (7 хоног)-ын ажлын төлөвлөгөөнд туссан байна.

#### **ХЦААБ-ын зохион байгуулалт:**

Хилийн цэргийн анги байгууллага нэг бүрд ХЦААБ-ын хөгжил, зохион байгуулалтыг тодорхойлогч нь:

ХЦААБ-ын зохион байгуулалтыг зохицуулагч эрх зүйн хэм хэмжээний бааз суурь (цэргийн нийтлэг дүрмүүд, ХХБ-ын цэргийн албыг зохион байгуулах заавар, ХЦААБ-ыг хангах заавар, хил хамгаалах албаны аюулгүй арга хэмжээний заавар, Хилийн цэргийн штабуудын албаны заавар);

ХЦААБ-ыг хангах асуудлыг хариуцсан албан тушаалтныг томилсон тушаал шийдвэр, хөгжлийн хэтийн төлөв;

хилийн цэргийн анги байгууллагын албан тушаалтны ХЦААБ-ыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа юм.

ХЦААБ-ыг хангахад хилчдийн гүйцэтгэх үүргийг дараах үндсэн чиглэлүүдээр тодорхойлдог. Үүнд:

1. хилчдийн амь нас эрсдэх, гэмтэл бэртэл авах төвшнийг бууруулахад чиглэсэн цэргийн өндөр сахилга дэг журам тогтоох;

Энэ чиглэлийн хүрээнд нийт алба хаагч нар:

- дүрэм журмыг дагаж мөрдөх, цэргийн сахилга дэг журмын норм хэмжээг мөрдөхдөө үлгэр жишээч байх;

- анги, салбарт сахилга дэг журамтай, ахмад настнаа хүндэтгэдэг байх эерэг уламжлалыг бий болгон төлөвшүүлэх;

- хууль, цэргийн дүрэм, журам зааврын шаардлагыг хэлбэрэлтгүй биелүүлэх ёстой.

2. ХЦААБ-ыг хангах гол чухал чиглэл нь хилчдийн хоорондын харилцаанд дүрмийн зөрчил гарах, бусад эрх зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх явдал юм.

Энэ чиглэлд хилчид:

- өөртөө өндөр шаардлага тавих;

- хоорондын харилцаанд дүрэм журмыг зайлшгүй мөрдөх бодит шаардлага байгаа болон түүнийг мөрдөхийн утга учрыг ухамсарлан дэс дараатайгаар тэр төвшинд хүрэх;

- харилцаандаа бие биеэ бүдүүлгээр доромжлон гомдоох байдлыг гаргахгүй байж, хамт алба хаагчдын хувь хүний давуу талыг нь хүндлэх.

3. хилчид амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх;

Энэ арга хэмжээг авч явуулахдаа цэргийн хамт олны дунд ёс суртахуун сэтгэл зүйн таатай нөхцөл байдал бий болгоход ихээхэн анхаарал хандуулж, цэргийн алба хаагчдын дунд дүрэм журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, сэтгэл зүйн нийцтэй байдлыг хангах нь зүйтэй.

4. зэвсэг, галт хэрэгсэлтэй ажиллах үеийн дүрэм журмыг мөрдөх ажлыг хангах. Зэвсэг, галт хэрэгсэл, тэсрэх бодис нь цэргийн өдөр тутмын үйл ажиллагааны нэг салшгүй хэсэг юм. Эдгээр нь хилчдийн өөрийнх нь төдийгүй бусдын амь насанд онц аюултай. Үүнээс үүдэн хилчид нэг бүр:

- өөрийн эзэмшиж буй зэвсгийн үзүүлэлтийг сайтар мэдэж байх;

- удирдамж, зааварт заасан шаардлагаар зохицуулагддаг зэвсэг, галт хэрэгсэлтэй ажиллах үеийн аюулгүйн арга хэмжээ, дүрэм журмыг мэддэг, мөрддөг байх ёстой;

- цэргийн сургуулилт, өдөр тутмын үйл ажиллагаа, харуулын алба, дотоод алба, байлдааны жижүүрийн явцад ХЦААБ-ыг өндөр төвшинд хангахын тулд тодорхой арга хэмжээнүүдийг чанд мөрдөж ажиллах ёстой.

Аливаа нөхцөлд хилчид хэрхэн биеэ авч явах журам нь аюулгүй байдлын шаардлагуудыг тодорхойлж, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль", "Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль", "Монгол улсын хилийн тухай хууль", "Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд", "Хил хамгаалалтын дүрмүүд", "Хил хамгаалах албаны аюулгүй ажиллагааны заавар", "Цэргийн албаны зохион байгуулалтын заавар", "Монгол улсын хилийн цэргийн штабуудын албаны заавар" зэрэг эрх зүйн хэм хэмжээний үндсэн долоон баримт бичиг, эдгээрийг нэгтгэсэн "ХЦААБ-ыг хангах заавар" эрх зүйн баримт бичгээр зохицуулагдана.

Хилийн цэргийн алба хаагч бүр бүх төрлийн ААХЗ, аюулгүй байдлын шаардлагыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх үүрэгтэй. Тэр өөрийн эрүүл мэндийг хамгаалахад

анхаарах, өдөр бүр тэсвэр хатуужил, биеийн тамирын бэлтгэл ба спортоор хичээллэх, хор хөнөөлтэй дадал (тамхи татах, архи хэрэглэх)-аас зайлсхийх, мансууруулах бэлдмэл ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнд автахгүй байх ёстой.

Энэ зорилгоор дараах үүрэг хүлээнэ:

- өөрийн албан тушаал ба тусгай үүргийг биелүүлэх аюулгүй арга болон барилыг судлах, цэргийн албаны аюулгүй байдлын шаардлагуудын талаар зааварчилгаа авах, байран дээр заасан үүргийг гүйцэтгэх дадлага хийх, түүнчлэн аюулгүй байдлын шаардлагуудыг биелүүлэх талаарх онолын мэдлэг ба практик дадлагын шалгалтыг өгөх;

- нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэх, түүнчлэн зайлшгүй тохиолдлуудад эмчилгээ-ариутгалын хэрэгслийг ашиглах

- өөрийн шууд захирах даргад цэргийн алба хаагчийн буруугаас цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд, орон нутгийн иргэдийн амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд заналхийлсэн нөхцөлийн тухай, эсвэл хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулсан тухай, түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааны арга хэмжээнүүдийг гүйцэтгэх үед түүнд эсвэл цэргийн алба хаагчийн гэмтэл бэртлийн баримт бүрийн тухай, эсвэл өөрийн эрүүл мэнд муудаж байгаа тухай яаралтай илтгэх;

- тогтоосон хугацаанд эмнэлгийн үзлэг (шинжилгээ)-т хамрагдах зэрэг болно.

Хилийн цэргийн анги бүр цэргийн алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны онцлог, шинжийг тусгасан өөрийн тусгай үүргүүдтэй байдаг ба аюулгүй байдлын заавар, цэргийн дүрэм нь ямар ч байдлаас хамаарахгүйгээр дурын нөхцөлүүдэд биелэгдэх ёстой. Ийм маягаар Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах нь хилийн цэргийн анги, салбарын албаны бэлэн байдлын чухал хүчин зүйл, үндэс болно.

ХЦААБ-ыг хангах зохион байгуулалтын арга хэмжээнүүд нь дараах байдлаар хэрэгжинэ. Үүнд:

- ХХЕГ, хилийн цэргийн ангийн Штаб нь ХЦААБ, дэг журам хангах, хэлтэс, албадуудын ажлын уялдааг хангах, цэргийн алба болон албаны бэлтгэлийн аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт, дадлагыг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлнэ;

- бүх шатны дарга, захирагч нар нь УХХ, ШНА, ХБАБ-ыг хангах, албаны амьтад, автомашин техник ашиглах үед хилчид гэмтэж бэртэх, амь үрэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна;

- хүн эмнэлгийн алба нь хилчдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн урьдчилан сэргийлэх болон эмчилгээний цогц арга хэмжээг зохион байгуулна;

- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, дотоод хяналтын хэлтэс, алба ХЦААБ-ыг хангах үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, залруулах, эрсдэлийн үнэлгээг хийх, алба хаагчдад туслах, эргэх холбоог хангаж ажиллана.

Түүнчлэн штаб, удирдах албан тушаалтан бүр алба үйл ажиллагаандаа ХЦААБ-ын тогтолцоог бүрдүүлэгч элементүүдийн аюулгүй байдлыг хангах 26 арга хэмжээ, ХЦААБ-ын хангах үйл ажиллагааны 11 чиглэлийг (нэмэлт-55) хэрэгжүүлэн зохион байгуулна.

ХЦААБ-ыг хариуцсан албан тушаалтнууд нь дараах арга хэмжээнүүдэд анхаарч ажиллана. Үүнд:

ХЦААБ-ыг хангах үйл ажиллагааны зорилго нь бие бүрэлдэхүүнд нөлөөлөх тодорхой аюул эрсдэлийн (харилцан хамаарал бүхий бүлэг, аюултай болон хортой хүчин зүйл) нөлөөллийг хамгийн бага төвшинд хүртэл бууруулах нөхцөлийг баталгаажуулах цэргийн албаны нөхцөл юм. Эдгээрт:

- Хилийн цагийн манаа, жижүүр, (алба) харуулын болон дотоод алба гүйцэтгэх, цэргийн зэвсэг техникийн ашиглалт, засварлах, сэргээн засах, ажил гүйцэтгэх, түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааны бусад үүргийг хэрэгжүүлэхдээ аюулгүй байдлыг хангах;

- ХЦААБ-ыг эмнэлгийн үйлчилгээний үүднээс хангах арга хэмжээ авч явуулах

- Хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн гамшиг, халдварт өвчин гарсан үед зохих арга хэмжээ авч явуулах, галын аюулгүй байдлыг хангах г.м.

Энэхүү үйл ажиллагааны зорилгоос үүдэн ХЦААБ-ыг хангах үндсэн зорилтуудыг дараах байдлаар ангилж үзэж болно. Үүнд:

- ЦАХ-дад албаны аюулгүй байдлын нөхцөлийг хангах хувийн хариуцлага бий болгох, амьдралын өөр өөр нөхцөлд аюулгүй ажиллах дадал чадварыг төлөвшүүлэх;

- сургалт, албаны бэлтгэл, зэвсэг техникийн ашиглалт, аж ахуй, барилгын ажлын явцад ЦАХ-ын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай аюулгүй

нөхцөлийг бүрдүүлэх;

- зэвсэг, техник, галт хэрэгсэлтэй ажиллах, хичээл, буудлага, хээрийн сургалт, өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх төрөл бүрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх;

- хилийн цэргийн анги байгууллагын бүх албан тушаалтнууд эдгээр зорилтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

ХЦААБ-ыг хангах ажлыг хилийн цэргийн анги байгууллагын бүх албан тушаалтнууд хариуцсан чиглэлээрээ хэрэгжүүлнэ.

Бие бүрэлдэхүүнтэй ажилладаг байгууллагууд цэргийн ангийн сахилга дэг журмын байдалд судалгаа хийж, түүнийг бэхжүүлэх арга хэмжээ боловсруулан, ажил зохион байгуулж, цэрэг амиа хорлох үйл явдал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

### **Дүгнэлт**

Хилийн цэргийн албаны аюулгүй байдал /ХЦААБ/ нь бүх төрлийн ААХЗ, дотоод албаны болон цэргийн дүрмүүдийг хэрэгжүүлэх цэргийн албаны зохион байгуулалт, цэргийн аж ахуйн болон улсын хил хамгаалалт, түүнд шаардлагатай үйл ажиллагаануудын стандартуудаас бүрдэх ба ЦАХ-дын албан үүргээ гүйцэтгэх үед учирч болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагаа, эрүүл аюулгүй орчин, ЦААБ-ыг хангахад тавих хяналт шалгалтын цогц юм.

Хил хамгаалах байгууллагад ХЦААБ-ыг хангах удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэгч нэгж нь “Цэргийн албаны аюулгүй байдлын комисс” юм.

ХЦААБ-ын удирдлага, зохион байгуулалтыг бүх шатны алба хаагч, нэгжүүд дараах байдлаар хариуцаж, хэрэгжүүлнэ. Үүнд:

1. ХХЕГ-ын хэмжээнд Штаб (ЦААБ-ын алба) хариуцаж, хэрэгжилтэд хяналт тавих нэгж нь Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;

2. хилийн цэргийн ангид штаб (ЦААБ хариуцсан ахлах офицер), дотоод хяналтын алба хамтран;

3. хилийн салбарт дарга, орлогч нар;

4. хилийн харуулд харуулын дарга;

5. хилийн манаанд манааны ахлагч;

6. хариуцагч албан тушаалтнууд нь бүх шатны дарга, захирагч;

7. хэрэгжүүлэгч нь бие бүрэлдэхүүн, орон нутгийн ард иргэд юм.

### **Санал**

Дээрх судалгаанаас үндэслэн ХЦААБ-ын удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиг үүрэг нь доорх арга хэмжээнүүдээс бүрдэнэ гэсэн санал дэвшүүлж байна. Үүнд:

1. ХЦААБ-ыг хангах ахлах даргын шийдвэр гаргах;

2. ХЦААБ-ыг хангах арга хэмжээг төлөвлөх;

3. ХЦААБ-ыг хангах арга хэмжээг зохион байгуулах;

4. ХЦААБ-ын хяналт, шалгалт;

5. ХЦААБ-ын дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ;

6. ХЦААБ-ын мэдээллийн бүртгэл хөтлөх зэрэг болно. Энэ нь өөрөө ХЦААБ-ыг хангах удирдлага, зохион байгуулалтын аргачлал болно.

### **Эх сурвалжийн жагсаалт**

Монгол Улсын Хилийн тухай хууль. Уб., 2016. 31 дүгээр зүйл

ОХУ-ын ЗХ-ний цэргийн албаны аюулгүй байдлыг хангах удирдамж. Мос., 2015. 2,2 дугаар зүйл

Полковник А.Медведев. преподаватель ВНУЦ СВ “Общевойсковая академия ВС РФ”

Цэргийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2014. 702х., т77;

Эрдэнэцогт.Д., “Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэслэл” сэдэвт докторын зэрэг горилсон диссертаци. Уб., 2002.140х, т65;

Түмэн.Б., “Байлдаанд цэргийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо”. Гарын авлага, Уб., 2005.30х, т3.

Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны зохион байгуулалтын заавар. Уб., 2019.1.1 дэх заалт

Пүрэвбаасан.В. “Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдлыг хангах арга зам” докторын судалгааны ажил. Уб., 2020. 3 дугаар бүлгээс.